

## ГАРЧИГ

1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	9
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	11
3.1 Агаарын чанар, агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	11
3.2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	12
3.3 Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	13
3.4 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	16
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	17
5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	26
6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	29
7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	33
8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	36
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	40

### Хавсралт материал

Хавсралт 1.	ААН-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээ .....	42
Хавсралт 2.	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл.....	44
Хавсралт 3.	Уурхайг ашиглалтанд хүлээн авсан тухай комиссын акт.....	48
Хавсралт 4.	Сум орон нутагтай хийсэн нийгмийн хариуцлагийн гэрээ.....	51
Хавсралт 5.	Тухайн жилийн усны ашиглалтын гэрээ, төлбөрийн баримт.....	54
Хавсралт 6.	Тухайн жилийн газар эзэмшлийн гэрээ, төлбөрийн баримт.....	60
Хавсралт 7.	Нөхөн сэргээлтийн ажлын баталгаа төлбөрийн баримт.....	64
Хавсралт 8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн лабораторийн шинжилгээний гэрээ, шинжилгээний хариу.....	65
Хавсралт 9.	Байгаль орчны төлөвлөгөөт аудитын “Ногоо гэрэлт ирээдүй” ХХК-тай байгуулсан гэрээ.....	74
Хавсралт 10.	Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд “Сэлэнгэ Ой Ан Төв” ХХК-тай байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээ.....	80
Хавсралт 11.	“Хай Би Ойл” ХХК-тай байгуулсан Техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэх гэрээ, хаягдал тос тушаасан баримт.....	82
Хавсралт 12.	Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Тохилог Хараа” ОНӨААТҮГ-тай байгуулсан Хог хаягдлын гэрээ.....	88
Хавсралт 13.	Сум орон нутгийн оршин суугчдын төлөөлөлтэй хамтарсан хурлын тэмдэглэл.....	91

### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.	MV-021071 тусгай зөвшөөрөлтэй 36.22 га талбайн солбилцол.....	5
Хүснэгт 2.	Агаарын чанар, агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний зардал.....	11
Хүснэгт 3.	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	12
Хүснэгт 4.	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	13
Хүснэгт 5.	Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	16
Хүснэгт 6.	2023 оны нөхөн сэргээлтийн ажлын зардал.....	18
Хүснэгт 7.	Техникийн жагсаалт.....	25
Хүснэгт 8.	Хүн хүчний жагсаалт.....	25
Хүснэгт 9.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	26
Хүснэгт 10.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	32
Хүснэгт 11.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан зардал.....	35
Хүснэгт 12.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт.....	37
Хүснэгт 13.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	40
Хүснэгт 14.	2023 оны байгаль орчны хамгаалах менежментийн төлөвлөгөөний зардлын нэгтгэл.....	41

### Зургийн жагсаалт

Зураг 1.	MV-021071 тусгай зөвшөөрлийн талбайн байршлын тойм зураг.....	4
Зураг 2.	Уурхайн кемпийн зохион байгуулалт.....	8
Зураг 3.	Замын тоосжилтыг дарсан байдал.....	12
Зураг 4.	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажил.....	14
Зураг 5.	Эфель гаалийн дүүргэлт хийж шимж хөрсөөр хучих явц.....	19
Зураг 6.	Биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр тариалах явц.....	20
Зураг 7.	Техник болон биологийн нөхөн сэргээлтийн дараах байдал.....	21
Зураг 8.	Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн өмнөх байдал.....	22
Зураг 9.	Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлын явц.....	23
Зураг 10.	Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн дараах байдал.....	24
Зураг 11.	Гал унтраах багаж хэрэгсэл, сургалт.....	27
Зураг 12.	ШТМ түгээх, хадгалах цэг.....	28
Зураг 13.	Уурхайн засварын талбай.....	28
Зураг 14.	Ахуйн хэрэглээний хог хаягдлыг түр хадгалах цэг.....	29
Зураг 15.	Уурхайн ойр орчимд тогтмол хийдэг цэвэрлэгээ, ухуулах самбар.....	29
Зураг 16.	Шингэн хог хаягдал хадгалах, хураах цэг, дахин боловсруулах байгууллага руу хүргэх.....	30
Зураг 17.	Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, хадгалах цэг.....	31
Зураг 18.	Ерөө голын дагуу хийсэн их цэвэрлэгээний ажлын явц.....	31
Зураг 19.	Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс шинжилгээ хийж буй ажлын явц.....	33
Зураг 20.	ХАБЭА, Байгаль хамгаалах, байгалийн баялаг ашиглах болон байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх сэдвээр зохион байгуулсан сургалтуудын явц.....	38
Зураг 21.	“Ногоо гэрэлт ирээдүй” ХХК-аас төлөвлөгөөт байгаль орчны аудит хийж буй ажлын явц.....	38
Зураг 22.	“Сэлэнгэ Ой Ан Төв” ХХК-аас Хүдэр суманд мод тарьж буй ажлын явц.....	39
Зураг 23.	Орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй хамтарсан хурал.....	41

## 1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах 36.22 га талбай бүхий MV-021071 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Бэрлэгийн цагаан тохой” алтны шороон ордыг “Бэрлэг майнинг” ХХК нь эзэмшдэг бөгөөд 2019 оноос эхлэн ашиглалт явуулж байна.


### Ерөнхий мэдээлэл

Компаний нэр:	“Бэрлэг майнинг” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9019004047
Регистрийн дугаар:	5007127
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар:	MV -021071
Ашиглалтын технологи:	Ил уурхай
Баяжуулалтын технологи:	Гравитаци

### Ордын байршил

Тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны хувьд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт харьяалагдах дэвсгэрт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн хойш 250 км, Дархан-Уул аймгаас зүүн урагш 170 км, Зүүнхараагаас зүүн хойш 70 км –т Бэрлэгийн цагаан тохойд оршино. Тус талбай нь Монгол орны байрзүйн зургийн М-48-107 –р хавтгайд байрлана.

Зураг 1. MV-021071 тусгай зөвшөөрлийн талбайн байршлын тойм зураг



Хүснэгт 1. MV-021071 тусгай зөвшөөрөлтэй 36.22 га талбайн солбицол

№	Өргөрөг	Уртраг
1	49° 8' 11.91"	107° 4' 06.32"
2	49° 8' 00.74"	107° 4' 06.32"
3	49° 7' 35.86"	107° 3' 41.31"
4	49° 8' 07.00"	107° 3' 41.31"
5	49° 8' 06.70"	107° 3' 42.08"
6	49° 8' 06.85"	107° 3' 44.02"
7	49° 8' 08.10"	107° 3' 44.06"
8	49° 8' 09.72"	107° 3' 44.13"
9	49° 8' 11.37"	107° 3' 42.55"
10	49° 8' 11.91"	107° 3' 41.77"

**Баяжуулах хэсгийн хүчин чадал**

Ордын элсийг угаан баяжуулах цехийн жилийн хүчин чадал 40.8-50.2 мян.м<sup>3</sup> ба угаах төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадал 40.0 м<sup>3</sup>/ц болон угаах цехийн цаг ашиглалт 75%-тай ажиллах үед жилд 113-140 хоног ажиллахаар ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлд тусгажээ.

**Уурхайн ашиглалтын систем**

Уг орд нь бага гүний орд бөгөөд уул-геологийн нөхцөл харьцангуй энгийн тул тээвэртэй ашиглалтын системээр ил аргаар ашигладаг. Иймд бульдозероор эхэлж шимт хөрсийг ил уурхайн хил хүрээний гадна талд түрж шимт хөрсний овоолго үүсгэсний дараа түүний доорхи хөрс болон элсэн давхаргыг экскаватор-автосамосвалын хослолоор зөөж тээвэрлэдэг.

Үндсэн хөрсийг эхний ээлжинд гадаад овоолгод байрлуулж, ашиглалтын хоосон орон зай үүсгэн шууд дотоод овоолго хийх замаар ажиллав. Энэ нь хөрс болон шимт хөрсний давхаргуудыг холихгүйгээр анх байсан төлөвт нь эргүүлэн оруулж нөхөн сэргээлт хийх боломжийг бүрдүүлсэн.

Алт агуулсан элсийг угаах төхөөрөмж байрласан талбайд зөөвөрлөн овоолго үүсгэн, үүссэн овоолгоосоо утгуурт ачигчаар угаах төхөөрөмжийг тэжээн ажиллалаа.

**Ордын нөөц, ашиглалтын нөөцийн тооцоо ба ашиглалт**

АМГТГ-ын даргын 2019 оны 6-р сарын 10-ны өдрийн н/44 тоот тушаалаар MV-021071 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах алтны эдийн засгийн үр ашигтай нөөцийг бодитой В зэрэглэлээр шлихээр 53.84 кг-аар, химийн цэврээр 49.0 кг-аар, боломжит С зэрэглэлээр шлихээр 5.72 кг-аар, химийн цэврээр 5.21 кг-аар, В+С зэрэглэлээр химийн цэврээр 54.21 кг-аар баталсан байна.

АМГТГ-ын даргын 2019 оны 8-р сарын 7-ны өдрийн Т/131 тоот тушаалаар MV-021071 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бэрлэгийн цагаан тохой нэртэй Ерөө голын зүүн дэнжийн /ХШ-570-580/ алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанд тооцсон байна.

Уг алтны шороон ордыг ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг эрх бүхий мэргэжлийн байгууллага “Дөрвөн талст Экологи” ХХК 2021 онд хийж гүйцэтгэсэн.

### **Уурхайн ажилласан горим**

Бэрлэгийн цагаан тохой алтны шороон ордын уурхай нь улирлын чанартай ажиллаж 8-р сарын 1-нээс 10-р сарын 15 хүртэл ажилласан.

### **Усан хангамжийн эх үүсвэр, усны хэрэглээ**

2023 оны ашиглалтын хугацаанд унд ахуйд 648.0 м<sup>3</sup> ус, үйлдвэрт 31,706.6 м<sup>3</sup> ус ашигласан бөгөөд үүнээс эргэлтээр 22,194.62 м<sup>3</sup>, нөхөн сэлбэлтээр 9,511.98 м<sup>3</sup> ус ашигласан.

Сум орон нутгаас худаг гаргах зөвшөөрөл авч 2021 оны 8-р сард тусгай зөвшөөрлийн талбайд ахуйн ундны усны хэрэгцээний зориулалттай худаг гаргасан. Тус худгаас дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэхэд “Ундны ус, эрүүл хуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018”-ын шаадлагыг хангаж байна.

### **Цахилгаан хангамжийн үүсвэр**

Бэрлэгийн цагаан тохой алтны шороон ордыг ашиглах төслийн хүрээнд цахилгаан хэрэглэгчид /уурхайн ус зайлуулах насос, гидрошлюзын угаан баяжуулах төхөөрөмж, уурхайн кемп/-ийн цахилгааныг зөөврийн 60-100 квт дизель цахилгаан үүсгүүрээр хангадаг.

### **Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн мэдээ**

2023 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд В-4 блокыг үргэлжлүүлэн, С-2 блокыг дуустал 47.75 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 9.65 мян.м<sup>3</sup> элс олборлон баяжуулахаар төлөвлөсөн.

2023 онд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаагаар эвдрэлд орсон дотоод овоолгоор 1.5 га талбайд, гадаад овоолгоор 2.4 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр, биологийн нөхөн сэргээлт, ургамалжуулалтын ажлын хүрээнд 6.8 га талбайд олон наст бэлчээрийн ургамал болон бусад төрлийн ургамлуудын үрийг тариалан биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр тус тус төлөвлөсөн байна.

2023 оны уулын ажлаар В-4 блокыг үргэлжлүүлэн баруун урагшаа ахилт хийн явуулсан. Нийт 20.84 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт хийж үүнээс 3.52 мян.м<sup>3</sup> элс олборлосон.

Уурхайн үйл ажиллагаа нь энэ жилийн усархаг хур борооны улмаас намагтай хэсэгт усны түвшин ихэссэн, карьерын усыг зайлуулахад хүндрэл гарсан, баяжуулах төхөөрөмжийн засварын ажлаас үүдэн сул зогсолт ихэссэн шалтгаануудын улмаас 2023 оны уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийг 70 орчим хувиар хангаж ажилласан.

Манай компани нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Цагаан тохой нэртэй MV-021071 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг эзэмшдэг бөгөөд Нийгмийн хариуцлагын хүрээнд болон 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасаны дагуу дараах нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

### **Нөхөн сэргээлтийн ажил**

Манай компани нь 2023 оны нөхөн сэргээлтийн ажлаар 2016 оны 5-р сарын 24-ний өдрийн БОНХАЖЯамнаас ирсэн 04/3/92 тоот албан бичгийн хүрээнд болон 2021 онд БОАЖЯамны дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийн шийдвэр, зөвлөмжийн дагуу MV-000435 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд урьд жилүүдэд компаниуд болон нөхөрлөлүүдийн ашиглаад орхисон хэсэгт биологийн нөхөн сэргээлтийн ажлыг нийт 4.0 га талбайд хийж гүйцэтгэв.

MV-021071 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн 2023 оны ашиглалтын явцад эвдрэлд орсон дотоод, гадаад овоолгоор 1.65 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэж, уг ажлаар шимт хөрсөөр хучих, согоовор, царгас тариалах, борнойдох ажлуудыг тус тус хийж гүйцэтгэв.

### **Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажил**

Манай компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд 2023 оны дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлаар тусгай зөвшөөрлийн талбайгаас зүүн хойд хэсэгт 450 орчим метр зайд байрлах Бэрлэгийн голын зүүн эргийн дагуу урьд өмнө нь ашиглаад нөхөн сэргээлт хийгээгүй орхисон усаар дүүрсэн ухсан нүх, эфель, гааль, шавар, шимт хөрсөөр холилдсон овоолго бүхий эвдрэлд орсон 3.01 га талбайд дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлыг 2023-10-10-аас 2023-10-15-ны хооронд 3 экскаватор, 2 том оврын ачааны автомашин, 2 бульдозер бүхий техникийн бүрэлдэхүүнтэй 12 хүнтэй ажлын хэсэг 2 ээлжээр 5 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэв.



## Уурхайн зохион байгуулалт

Зураг 2. Уурхайн кемпийн зохион байгуулалт



## 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ил уурхайн олборлолтын явцад байгаль орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг. Ил уурхайн олборлолтын явцад анхаарах гол зүйл бол технологийн дагуу гүйцэтгэх, ил уурхайн ойр орчмын хөрс, ургамлан бүрхэвчийг хамгаалах явдал юм. Иймээс байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуух ажлуудыг хангаж ажилласан болно.

Байгаль орчны 2023 оны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө зэрэгт тусгагдсан арга хэмжээнүүдийн цаг тухайд нь авч хэрэгжүүлсэн.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам зэргийг удирдлага болгон ажилласан.

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахын дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- ✓ Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарч ажиллаа.
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажилласан.
- ✓ Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад тогтмол хугацаанд сургалт зохион байгуулан ажилласан.
- ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны ХБОБНУГ-аар батлуулж, төлөвлөгөөний дагуу хяналт-шинжилгээ Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг “Ногоо гэрэлт ирээдүй” ХХК-тай байгуулсан 2022/09 тоот гэрээний дагуу аудит хийлгэж хамтран ажиллаж байна.
- ✓ 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-тэй байгуулсан №27 тоот гэрээний дагуу Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээг ус, хөрс, агаараас дээж авч шинжлэхэд хэвийн хэмжээнд байгаа нь шинжилгээний хариугаар гарсан.
- ✓ Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд манай компани нь “Сэлэнгэ Ой Ан Төв” ХХК-тай Ажил гүйцэтгэх гэрээгээр хамтран ажиллаж гэрээний дагуу Хүдэр суманд 0.5 га талбайд Навчит модны суулгац тарьж ургуулан хамтран ажиллаж байна.
- ✓ Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд ахуйн хог хаягдлаа Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Тохилог Хараа” ОНӨААТҮГ-тай №57 тоот Хог хаягдлын гэрээ байгуулан хамтран ажиллаж, гэрээний дагуу ахуйн хог хаягдлыг



төвлөрсөн хогийн цэгт хаясан. Тоног төхөөрөмж, засварын газар болон үйлдвэрлэлийн үүсэлтэй металл хаягдлыг тусгай талбайд хашлага хийн цуглуулж, тээвэрлэн борлуулахад бэлтгэн хурааж, УБ хот дахь түүхий эд авах цэгт тушаасан. Машин техникээс гарсан ажилласан тос, маслыг битүүмжлэл бүхий саванд цуглуулан, дахин боловсруулах зөвшөөрөл бүхий “Хай Би Ойл” ХХК-тай байгуулсан №23/05 тоот “Техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэх гэрээ”-ний дагуу хаягдал тосоо нийлүүлэн ажиллалаа.

- ✓ 2023 оны уулын ажлын дараа нийт ашиглалтын талбай болон Ерөө голын гольдрол, эрэг дэхь хогийг цэвэрлэн Мандал сумын төвлөрсөн хогийн цэгт хаясан.
- ✓ Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах зорилгоор “Бэрлэг Майнинг” ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргатай №03 тоот “Нийгмийн хариуцлагын гэрээ” байгуулан гэрээний хүрээнд орон нутагт Байгаль орчинг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг цаг тухайд нь танилцуулж харилцан уялдаатай ажиллав.

### 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

#### 3.1 Агаарын чанар, агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 2

№	Төлөвлөлт	Биелэлт	Зардал, мян.төг
1	Тоосжилтыг багасгахын тулд олборлолт явуулж байсан талбай, дутуу хэлбэржүүлсэн овоолго, ашиглаж байгаа болон ашиглахгүй байгаа зам талбайг тодорхой графикаар усалж чийглэнэ.	Тоосжилтыг багасгахын тулд олборлолт явуулж байсан талбай, дутуу хэлбэржүүлсэн овоолго, ашиглаж байгаа болон ашиглахгүй байгаа зам талбайг бороо хур ороогүй үед 7 хоногт 1-2 удаа усалж чийглэсэн.	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан
2	Шороон замыг аль болохоор дагтаршуулан засварлана, олон салаа зам гаргахгүй, замын тэмдэглэгээ хийж, автомашин тээврийн хэрэгсэлийн хурдыг хязгаарлана	Ашиглахгүй болсон шороон замыг бульдозер, уггуурт ачигчийн тусламжтай дагтаршуулан засварлаж, олон салаа зам гаргахгүй, замын тэмдэглэгээ хийж, автомашин тээврийн хэрэгсэлийн хурдыг хязгаарлаж ажиллав.	2000.0
3	Уурхайн ашиглахаа больсон замуудын тоосыг бууруулах цаашид ашиглахгүй бол нөхөн сэргээлт хийж ургамалжуулах ажлуудыг хийж, усаар тогтмол усалж тоосыг дарна.	Уурхайн ашиглахаа больсон замыг хар шороон хөрсөөр хучин нөхөн сэргээлт хийж ургамалжуулах ажлыг гүйцэтгэсэн.	1000.0
4	Хөдөлгүүрт техникийн засвар үйлчилгээ, тохируулгыг тогтсон хуваарийн дагуу байнга хийж хүнд даацын машин, механизмын дотоод шаталтат хөдөлгүүрийн янданд шүүлтүүр тавьж, жил бүрийн техникийн үзлэгээр утаан дахь хорт хийн агууламжийг хянуулж, багасгах арга хэмжээг авч ажиллана.	Манай уурхай нь сүүлийн үеийн дэвшилтэт техник, машин механизмыг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа ба нийт машин механизмуудыг тогтмол засвар үйлчилгээнд хамруулан, тухайн оны техникийн үзлэг оношлогоондоо орсон болно. Иймээс хорт утааны ялгаралт стандартын түвшинд байх үндэслэлийг бий болгож байгаа юм.	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан
5	Ил задгай хог хаягдал шатаахгүй байх	Ил задгай хог хаягдал шатаахгүй байх талаар ажилчдад сургалт, ухуулга зохион байгуулав.	600.0
6	Ажилчдын хотхоны уурын зуухын хэвийн ажиллагааг хангах, бүрэн шаталттай нүүрс түлэх	Ажилчдын хотхоны уурын зуухын хэвийн ажиллагааг хангаж, бүрэн шаталттай байх үүднээс мод түлэх, мөн цахилгаан хэрэгсэл түлхүү ашиглаж байв.	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан
	<b>Дүн</b>		<b>3600.0</b>

Зураг 3. Замын тоосжилтыг дарсан байдал



### 3.2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 3

№	Төлөвлөлт	Биелэлт	Зардал, мян.төг
1	Голын гольдролыг өөрчлөхгй байх, гадаргуугын усанд бохирдолт үүсгэхгүй байх	Голын гольдролыг өөрчлөөгүй ба гадаргуугын усанд бохирдолт үүсгэхгүй байх тал дээр анхаарч хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис материалыг зориулалтын дагуу хадгалж, хяналт тавин, газрын гадаргуугын болон гүний усыг хамгаалж ажилласан.	-
2	Үйлдвэрлэлийн болон ахуйн ус хэрэглээний хэмжээг нарийвчлан тооцож, усыг дахин хэрэглэх, хэмнэлттэй зарцуулах техник технологи ашиглах	ТӨҮГ-Усны газрын 2023/5/12-ны өдрийн Ус ашиглах дүгнэлтээр үйлдвэрлэлийн болон ахуйн усны хэмжээг нарийвчлан тодорхойлуулав.	645.0
3	Уурхайн үндсэн талбайг үерийн уснаас сайтар хамгаалж суваг шуудуу ба далан хаалтыг нэмж сайжруулах	Уурхайн үндсэн талбайг үерийн уснаас сайтар хамгаалж суваг шуудуу ба далан хаалтыг нэмж сайжруулалт хийв.	Үйл ажиллагааны зардалд орсон
4	Үйлдвэрлэлийн болон ахуйн бохир усыг зохих стандартын түвшинд цэвэршүүлж тунгаасны дараа хөрсөнд болон усанд нийлүүлж буйг хянах	Үйлдвэрлэлийн ашигласан усыг тунаах нуураар дамжуулан цэвэршүүлж 70%-ийг дахин ашиглаж байна. Ахуйн бохир усыг зохих стандартын түвшинд цэвэршүүлж тунгаасны дараа хөрсөнд шингээж байв.	Үйл ажиллагааны зардалд орсон
5	Унд ахуйн ус эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоож ашиглах	Сум орон нутгаас худаг гаргах зөвшөөрөл авч 2021 оны 8-р сард тусгай зөвшөөрлийн талбайд ахуйн ундны усны хэрэгцээний зориулалттай худаг гаргасан. Тус худагас дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэхэд “Ундны ус, эрүүл хуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018”-ын шаадлагыг хангаж	Үйл ажиллагааны зардалд орсон

		байна.	
6	Ус ашиглалтын гэрээг Хараа-Ерөө сав газрын захиргаатай хийж, ус ашиглалтын төлбөрийг сумын байгаль орчны тусгай дансанд оруулах	Хараа-Ерөө голын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулан 2023 онд ашигласан усны төлбөрийг харьяа татварын албаны тусгай дансанд байршуулсан.	9461.081
7	Уурхайн дэвсгэр дэх засварын талбай, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрд болон уурхайн хүнд машин техник, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах, ШТМ алдагдсан тохиолдолд түүнийг үл нэвчүүлэх, цуглуулах боломжийг бүрдүүлэх, бохирдлыг цэвэрлэх саармагжуулах	Уурхайн дэвсгэр дэх засварын талбай, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрт болон уурхайн хүнд машин техник, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгаж, ШТМ алдагдсан тохиолдолд түүнийг үл нэвчүүлэх, цуглуулах боломжийг бүрдүүлэн, бохирдлыг цэвэрлэж саармагжуулж байв.	1200.0
	<b>Дүн</b>		<b>11306.081</b>

### 3.3 Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 4

№	Төлөвлөлт	Биелэлт	Зардал, мян.төг
1	Ашиглалт явуулах болон хаягдлын овоолго хийх талбайн үржил шимт хөрсийг тусад нь хуулж 5 м-ээс өндөргүй овоолон хадгалах	Ашиглалт явуулсан болон хаягдлын овоолго хийсэн талбайн үржил шимт хөрсийг тусад нь хуулж 5 м-ээс өндөргүй овоолон хадгалж байв. Овоолсон шимт хөрсийг салхинд хийсэх болон үерийн усанд урсахаас хамгаалахаар зохион байгуулсан.	Үйл ажиллагааны зардалд орсон
2	Урьд жилүүдэд хийсэн уурхайн замын тэмдэгжүүлэлт, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбарыг шинэчлэн хийж, ухуулга сурталчилгаа хийх	Олон салаа зам хөрс эвдлэх аюултайг тооцож замын сүлжээг цэгцтэй болгож үйлдвэрийн технологийн замуудын эхэнд анхааруулах тэмдэг тавих, бусад тэмдэглэгээг засварлан, шинээр тавьж тэмдэгжүүлэв.	1200.0
4	Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх, хаягдлыг цуглуулж цэвэрлэн эргүүлж ашиглах арга хэмжээг төлөвлөх, бохирдсон хөрсийг цэвэрлэх, зайлуулах арга хэмжээ авах	Шатах, тослох материалыг зориулалтын ёмкст хадгалж, орчинд асгарч алдагдахаас сэргийлж хадгалах талбайг хатуу хучилттай болгож, бохирдсон хөрсийг цэвэрлэж, зайлуулах арга хэмжээг тухай бүрт нь авч байв. Машин техникээс гарсан ажилласан тос, маслыг цулуулан, дахин боловсруулах зөвшөөрөл бүхий “Хай Би Ойл” ХХК-тай Техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулан гэрээний дагуу хаягдал тос нийлүүлсэн.	150.0
5	Машин механизмын засвар үйлчилгээг хатуу хучилттай талбайд хийх, засварын газар байгуулах	Машин механизмын засвар үйлчилгээг тусгай зориулалтын засварын талбайд хийж байсан.	Урд жилүүдэд бий болгосон байгаа



6	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сард 1 удаа сургалт зохион байгуулсан.	600.0
7	Газар шорооны болон барилга байгууламжийн ажлын үед эвдэрсэн газрыг засч тэгшлэх, ухагдсан орон зайд нөхөн дүүргэлт хийж биологийн нөхөн сэргээлт хийх.	Газар шорооны ажлын үед эвдэрсэн газрыг засч тэгшлэх, ухагдсан орон зайд нөхөн дүүргэлт хийж биологийн нөхөн сэргээлтийг тогтмол хийж гүйцэтгэсэн. /1.65 га/	Нөхөн сэргээлтийн зардалд орсон
8	Шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хийх	Үндсэн хөрсийг эхний ээлжинд гадаад овоолгод байрлуулж, ашиглалтын хоосон орон зай үүсгэн шууд дотоод овоолго хийх замаар ажиллав. Энэ нь хөрс болон шимт хөрсний давхаргуудыг холихгүйгээр анх байсан төлөвт нь эргүүлэн оруулж нөхөн сэргээлт хийх боломжийг бүрдүүлсэн.	Нөхөн сэргээлтийн зардалд орсон
9	Хөрсний овоолгыг нуралт, гулсалтаас хамгаалах	Хөрсний овоолгыг нуралт, гулсалтаас хамгаалж байв.	Үйл ажиллагааны зардалд орсон
10	Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлаж байх зорилгоор жолооч операторуудад ухуулга сурталчилгааг хийж, зам дагуу тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг тогтоосон болон маршрут чиглэлийг заасан тэмдэглэгээ хийсэн.	Урд жилүүдэд бий болгосон байгаа
<b>Дүн</b>			<b>1950.0</b>

Зураг 4. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлуудаас:

- Үржил шимт хөрсний овоолго



- Замын тэмдэг, тэмдэглэгээ



- ШТМ-ын зориулалтын хадгалах ёмкост



- Ашигласан тос, маслын хадгалах, хураах цэг





### 3.4 Биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн хамгаалал хийх чиглэлээр авч хэрэгжлэх арга хэмжээний биелэлт

Хүснэгт 5

№	Төлөвлөлт	Биелэлт	Зардал, мян.төг
1	Ургамал устгах, талхлагдахаас сэргийлэх арга хэмжээ авч, бэлчээрийн талбайг багасгахгүй байх	Ургамлан нөмрөгийг устгах, талхлагдахаас сэргийлж, хүн, техникийн хөдөлгөөнд хязгаарлалт тавьж авто замуудаар зорчих хөдөлгөөнийг хэвшүүлж хяналт тавьж, шороон асгацууд бий болгохгүй байх, талбайн ашиглалтын зохион байгуулалтыг сайжруулан ажиллав.	Үйл ажиллагааны зардалд орсон
2	Ажилчдын кемп, дээр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Өмнөх жилийн байгуулсан ажилчдын кемп дэх ногоон байгууламжийг усалж тордож байв.	Үйл ажиллагааны зардалд орсон
3	Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт ухуулга хийх ажлыг 8-р сард зохион байгуулсан.	300.0
4	Өвчилсөн, байгалийн гамшиг болон бусад аюулд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах	Өвчилсөн, байгалийн гамшиг болон бусад аюулд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэхэд бэлэн байдалд ажилласан.	Гамшигийн үеийн буюу зайлшгүй үеийн зардалд тусгагдсан
5	Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр ажилчдад сургалт явуулах	Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр ажилчдад 8-р сард сургалт зохион байгуулав.	300.0
6	Хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад онцгой анхаарах	Хууль бус агнуур хийхгүй байх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэхгүй байх зорилгоор ажилчдад ухуулга сурталчилгааг тогтмол хийж, 8-р сард энэ чиглэлээр сургалт зохион байгуулав.	300.0
	<b>Дүн</b>		<b>900.0</b>

#### **4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Бэрлэгийн цагаан тохойн алтны шороон ордын нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008”, “MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008” стандартын шаардлагад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэсэн.

2023 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд В-4 блокыг үргэлжлүүлэн, С-2 блокыг дуустал 47.75 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 9.65 мян.м<sup>3</sup> элс олборлон баяжуулахаар төлөвлөсөн.

2023 онд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаагаар эвдрэлд орсон дотоод овоолгоор 1.5 га талбайд, гадаад овоолгоор 2.4 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр, биологийн нөхөн сэргээлт, ургамалжуулалтын ажлын хүрээнд 6.8 га талбайд олон наст бэлчээрийн ургамал болон бусад төрлийн ургамлуудын үрийг тариалан биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр тус тус төлөвлөсөн байна.

2023 оны уулын ажлаар В-4 блокыг үргэлжлүүлэн баруун урагшаа ахилт хийн явуулсан. Нийт 20.84 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт хийж үүнээс 3.52 мян.м<sup>3</sup> элс олборлосон.

Уурхайн үйл ажиллагаа нь энэ жилийн усархаг хур борооны улмаас намагтай хэсэгт усны түвшин ихэссэн, карьерын усыг зайлуулахад хүндрэл гарсан, баяжуулах төхөөрөмжийн засварын ажлаас үүдсэн сул зогсолт ихэссэн шалтгаануудын улмаас 2023 оны уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийг 70 орчим хувиар хангаж ажилласан.

##### **Нөхөн сэргээлтийн ажил**

Манай компани нь 2023 оны нөхөн сэргээлтийн ажлаар 2016 оны 5-р сарын 24-ний өдрийн БОНХАЖЯамнаас ирсэн 04/3/92 тоот албан бичгийн хүрээнд болон 2021 онд БОАЖЯамны дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийн шийдвэр, зөвлөмжийн дагуу MV-000435 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд урьд жилүүдэд компаниуд болон нөхөрлөлүүдийн ашиглаад орхисон хэсэгт биологийн нөхөн сэргээлтийн ажлыг нийт 4.0 га талбайд хийж гүйцэтгэв.

MV-021071 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн 2023 оны ашиглалтын явцад эвдрэлд орсон дотоод, гадаад овоолгоор 1.65 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэж, уг ажлаар шимт хөрсөөр хучих, согоовор, царгас тариалах, борнойдох ажлуудыг тус тус хийж гүйцэтгэв.

##### **Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажил**

Манай компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд 2023 оны дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлаар тусгай зөвшөөрлийн талбайгаас зүүн хойд хэсэгт 450 орчим метр зайд байрлах Бэрлэгийн голын зүүн эргийн дагуу урьд өмнө нь ашиглаад нөхөн сэргээлт хийгээгүй орхисон усаар дүүрсэн ухсан нүх, эфель, гааль, шавар, шимт



хөрсөөр холилдсон овоолго бүхий эвдрэлд орсон 3.01 га талбайд дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлыг 2023-10-10-аас 2023-10-15-ны хооронд 3 экскаватор, 2 том оврын ачааны автомашин, 2 бульдозер бүхий техникийн бүрэлдэхүүнтэй 12 хүнтэй ажлын хэсэг 2 ээлжээр 5 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэв.

Уулын ажил дууссаны дараа олборлолтонд өртсөн талбайг дотоод овоолгоор түрж тэгшлэн хэлбэршүүлэх ба нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, түүнд зарцуулагдах зардал, биологийн нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ болон зардлыг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 6. 2023 оны нөхөн сэргээлтийн ажлын зардал

Үзүүлэлт	Ажлын хэмжээ, га	Нэгж өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар
Техникийн нөхөн сэргээлт	1.65	28000.0	46200.0	В-4 блокт хөрсний гадаад болон дотоод овоолгоор ухагдсан сул орон зайг нөхөн дүүргэх, талбайг тэгшлэх, хэлбэршүүлэх, нягтруулах ажлууд хийгдсэн.
Биологийн нөхөн сэргээлт	1.65	12000.0	19800.0	Талбайг шимт хөрсөөр хучих, согоовор, царгас тариалах, борнойдох ажлууд хийгдсэн.
Дүйцүүлэн хамгаалах ажил	3.01	28000.0	84280.0	Ухсан нүхийг хурдас чулуулгаар дүүрэглт хийх, овоолгыг түрж тэгшлэх, хэлбэршүүлэх, нягтаршуулах ажлууд хийгдсэн.
<b>Нийт</b>			<b>150280.0</b>	

#### Бусад ажил:

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-тэй байгуулсан №27 тоот гэрээний дагуу Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээг ус, хөрс, агаараас дээж авч шинжлэхэд хэвийн хэмжээнд байгаа нь шинжилгээний хариугаар батлагдсан. Дээжний хариуг хавсаргав.

Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд манай компани нь “Сэлэнгэ Ой Ан Төв” ХХК-тай Ажил гүйцэтгэх гэрээгээр хамтран ажиллаж гэрээний дагуу Хүдэр суманд 0.5 га талбайд Навчит модны суулгац тарьж ургуулан хамтран ажиллаж байна.

Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд ахуйн хог хаягдлаа Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Тохилог Хараа” ОНӨААТҮГ-тай №57 тоот Хог хаягдлын гэрээ байгуулан хамтран ажиллаж, гэрээний дагуу ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаясан. Тоног төхөөрөмж, засварын газар болон үйлдвэрлэлийн үүсэлтэй металл хаягдлыг тусгай талбайд хашлага хийн цуглуулж, тээвэрлэн борлуулахад бэлтгэн хурааж, УБ хот дахь түүхий эд авах цэгт тушаасан. Машин техникээс гарсан

ажилласан тос, маслыг битүүмжлэл бүхий саванд цуглуулан, дахин боловсруулах зөвшөөрөл бүхий “Хай Би Ойл” ХХК-тай байгуулсан №23/05 тоот “Техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэх гэрээ”-ний дагуу хаягдал тосоо нийлүүлэн ажиллалаа. 2023 оны уулын ажлын дараа нийт ашиглалтын талбай болон Ерөө голын гольдрол, эрэг дэхь хогийг цэвэрлэн Мандал сумын төвлөрсөн хогийн цэгт хаясан.

Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах зорилгоор “Бэрлэг Майнинг” ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргатай №03 тоот “Нийгмийн хариуцлагын гэрээ” байгуулан гэрээний хүрээнд орон нутагт Байгаль орчинг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг цаг тухайд нь танилцуулж харилцан уялдаатай ажиллав.

Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг “Ногоо гэрэлт ирээдүй” ХХК-тай байгуулсан 2022/09 тоот гэрээний дагуу аудит хийлгэж хамтран ажиллаж байна.

Нөхөн сэргээлтийн ажлын фото зургийг хавсаргав.

Зураг 5. Эфель гаалийн дүүргэлт хийж шимж хөрсөөр хучих явц



Зураг 6. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр тариалах явц





Зураг 7. Техник болон биологийн нөхөн сэргээлтийн дараах байдал





Зураг 8. Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн өмнөх байдал





Зураг 9. Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлын явц





Зураг 10. Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн дараах байдал



Хүснэгт 7. Техникийн жагсаалт

№	Техникийн нэр	Тоо ширхэг	Төрөл
1	DISD – 300 маркын экскаватор	1	өөрийн
2	HITACHI - 200 маркийн экскаватор	1	өөрийн
3	KOMATSU - 65 маркийн бульдозер	1	өөрийн
4	NORD - BENZ маркийн ачаа ачигч	2	түрээсийн
5	HOWO – маркийн ачаа ачигч	2	түрээсийн
6	YUN2 665 - маркийн утгуурт ачигч	1	өөрийн
7	Forland маркийн түлш цэнэглэгч	1	өөрийн
8	Ланд крузер - 100 маркийн суудлын авто машин	1	өөрийн

Хүснэгт 8. Хүн хүчний жагсаалт

№	Албан тушаал	Тоо хэмжээ, хүн	Төрөл
1	Ахлагч ХАБЭА-н ажилтан	1	өөрийн
2	Экскаваторын оператор	4	өөрийн
3	Бульдозерын оператор	2	өөрийн
4	Жолооч оператор	6	түрээсийн
5	Нярав, түгээгч	1	өөрийн
6	Утгуурт ачигчийн оператор	1	өөрийн



## 5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн хүрээнд олборлосон элсийг уурхайн талбайд скруберээр баяжуулна. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер, техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Зардал, мян.төг
Түлшний агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй. Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр гал гарч болзошгүй.	Бүх ажилчдыг гал түймэр унтраах компанийн дотоод сургалтад хамруулсан	1500.0
	Гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулсан.	
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулсан.	
Ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө өдөр бүр аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулдаг.	800.0
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны сургалтыг нийт ажилтанд 8 болон 10-р сард зохион байгуулсан.	
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	Жолооч, оператор нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд 7-р сард хамруулсан; Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулсан;	600.0
	Жолооч бүрийг даатгалд хамруулсан;	
	Машины кабин бүрт эмийн сан, галын хор байрлуулсан;	
<b>Нийт зардал, мян.төг</b>		<b>2900.0</b>

**Гал түймэр:** Уг нутаг дэвсгэр нь гал түймэрийн аюул осол ихтэй бүс нутагт хамаарах бөгөөд хавар, намрын улиралд салхи, шуурга ихтэй байдаг учир ил задгай газарт гал гарахаас болгоомжлох нь чухал.

Уурхайн жил бүрийн уулын ажлын төлөвлөгөө болон аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгаж гал унтраах багаж хэрэгслээр хангаж ажилласан.

Зураг 11. Гал унтраах багаж хэрэгсэл, сургалт



**Хөрс:** Хөрсийг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материалыг ил задгай асгахгүй байх зэрэгт анхаарч ажилласан. Шатах тослох материалын хадгалах агуулах, засвар үйлчилгээний талбай, хаягдал тос, тосон бүтээгдэхүүний агуулах зэргийг үер ус, галын аюулд өртөхөөргүй газарт сонгон байгуулсан.

Шатах тослох материал, хаягдал тос-тосон бүтээгдэхүүний агуулах зэрэгт санамсаргүй тохиолдлоор асгарахаас урьдчилан сэргийлж сануулга, самбар, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулж, тусгайлан сургалт явуулсан. Мөн эрсдэлийн үед хэрэглэх эд материал, элс хайрга, галын аюулгүйн булан байгуулж, онцгой бүсийн тусгай тэмдэг тэмдэглэгээг байрлуулж ажиллаа. Уурхайн бүсэд хөрсний дээж авхуулж химийн шинжилгээ хийлгэсэн.

Хөрс чулуулаг болон ургамлын био давхаргын бүрхэвчийг гэмтээж хордуулахгүй байх ухамсарт суралцуулан ажиллаж байна.

Зураг 12. ШТМ түгээх, хадгалах цэг



Зураг 13. Уурхайн засварын талбай



Олон салаа зам хөрс эвдлэх аюултайг тооцож замын сүлжээг цэгцтэй болгож үйлдвэрийн технологийн замуудыг хийж, замуудын эхэнд анхааруулах тэмдэг тавьж тэмдэгжүүлсэн. Сургалт, ухуулах сурталчилгааг тогтмол явуулж ажиллаа.

"Цагаан тохой" алтны шороон ордод алт агуулсан баяжмалыг баяжуулахад усаар угаан хүндийн хүчний буюу гравитацийн аргаар баяжуулдаг учир ямар нэгэн химийн бодис ашигладаггүй. Иймд баяжуулах үйлдвэрт ямар нэгэн химийн бодис хэрэглээгүй болно.



## 6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаа явагдаж эхлэхэд хог хаягдал гарснаар тухайн газар нутгийг бохирдуулах, мөн ажиллаж амьдарч байгаа ажилчид, нутгийн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай тул дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

Уурхайн хог хаягдлыг дараах байдлаар ангилсан. Үүнд:

1. Ахуйн хэрэглээний хог хаягдал
2. Шингэн хог хаягдал
3. Хатуу хог хаягдал

**Ахуйн хэрэглээний хог хаягдалд:** Ажилчдын байрнаас гарах хог, цайны газраас гарах хаягдал, ажлын байрны хог, тосгоноос гарах хог хаягдлууд багтана. Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд ахуйн хог хаягдлаа Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Тохилог Хараа” ОНӨААТҮГ-тай №57 тоот Хог хаягдлын гэрээ байгуулан хамтран ажиллаж, гэрээний дагуу ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаясан. 2023 оны уулын ажлын дараа нийт ашиглалтын талбай болон Ерөө голын гольдрол, эрэг дэхь хогийг цэвэрлэн Мандал сумын төвлөрсөн хогийн цэгт хаясан.

Зураг 14. Ахуйн хэрэглээний хог хаягдлыг түр хадгалах цэг



Зураг 15. Уурхайн ойр орчимд тогтмол хийдэг цэвэрлэгээ, ухуулах самбар



**Шингэн хог хаягдалд:** Уурхайн хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээ хийгдсэний дараагаар сольсон тос, шүүр, ахуйн хэрэглээний бохирын ус гэх мэт хаягдал гардаг. Машин техникээс гарсан ажилласан тос, маслыг



битүүмжлэл бүхий саванд цуглуулан, дахин боловсруулах зөвшөөрөл бүхий “Хай Би Ойл” ХХК-тай байгуулсан №23/05 тоот “Техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэх гэрээ”-ний дагуу хаягдал тосоо нийлүүлэн ажиллалаа.

Ахуйн хэрэглээний шингэн бохирын хаягдлыг цооног байгуулан түүнд зайлуулан ариутгалыг тогтмол хийж ашиглалтын хугацаа дуусахад ариутган дарж булшлах арга хэмжээг авсан. Үүнээс гадна бие засах газрын битүүмжлэлийг сайн хийж, тогтмол ариутгал цэвэрлэгээ хийх арга хэмжээг авч ажилласан.

Зураг 16. Шингэн хог хаягдал хадгалах, хураах цэг, дахин боловсруулах байгууллага руу хүргэх



**Хатуу хог хаягдалд:** Уурхайн механик цех, токарийн суурь машин, засвар үйлчилгээ хийгдсэн машин механизмаас гарах хатуу хог хаягдлууд орно. Тоног төхөөрөмж, засварын газар болон үйлдвэрлэлийн үүсэлтэй металл хаягдлыг тусгай талбайд хашлага хийн цуглуулж, тээвэрлэн борлуулахад бэлтгэн хурааж, УБ хот дахь түүхий эд авах цэгт тушаасан.



Зураг 17. Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, хадгалах цэг



Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг зайлуулахдаа дараахь дэс дарааллыг баримталж ажилласан.

- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь арилгах, бууруулах
- Хаягдал бүтээгдэхүүнийг дахин ашиглах /хэрэв шаардлагатай бол сэргээн зассаны дараа/

Зураг 18. Ерөө голын дагуу хийсэн их цэвэрлэгээний ажлын явц



Хүснэгт 10. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Зардал, мян.төг
Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах нь хог хаягдлыг дахин ялгах	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг ажилчдын хотхон, засварын газар, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих ажлыг хийж гүйцэтгэсэн. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж байна.	400.0
Хог хаягдлаар хөрс, газрын доорхи ус бохирдож болзошгүй	Хог хаягдал түр хадгалах талбайг шимт хөрсийг нь хуулан цементлэн нэвчилт явагдахааргүй болгосон. /өмнөх жил хийгдсэн талбайг сэргээн засварласан./	
Төслийн үйл ажиллагаанаас үүсэх ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаар хөрс, гадаргын болон газрын доорхи ус бохирдуулах сөрөг нөлөөтэй	Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг түр цуглуулан хадгалж 2-догч түүхий эд авах цэгт тушаасан	800.0
	Дугуйн хаягдлыг байгальд шууд хаялгүй тусгай талбайд цуглуулж 2-догч түүхий эд авах цэгт тушаасан	
	Автомашинны сэлбэг, төмрийн хаягдлыг тусгай талбайд цуглуулж 2-догч түүхий эд авах цэгт тушаасан	
	Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулдаг. Боломжтой хог хаягдлыг дахин ашиглах зарчмаар ажилладаг. Үүний нэг нь хаягдал цаасыг гал түлэхэд ашиглах, хаягдал төмөр, сэлбэгийг сэлгэн засаж ашиглах гэх мэт	
Ахуйн аюултай хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорхи ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдал буюу тос маслыг цулуулах, дахин боловсруулах зөвшөөрөл бүхий “Хай Би Ойл” ХХК-тай Техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулан гэрээний дагуу хаягдал тосоо тушаасан.	180.0
Ажилчид санаатай болон санамсаргүйгээр ил задгай хог хаях	Уурхайн ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалтыг 8-р сард зохион байгуулсан.	500.0
<b>Нийт зардал, мян.төг</b>		<b>1880.0</b>



## 7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Тухайн төслийг хэрэгжүүлсэнээс үүдэн байгаль орчин, нутгийн иргэд, ажиллагсадын амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зохих стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хязгаарт байгаа эсэхийг хянах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт хийх зорилгоор Сэлэнгэ аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-тэй байгуулсан №27 тоот гэрээний дагуу Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээг ус, хөрс, агаараас дээж авч шинжлэхэд хэвийн хэмжээнд байгаа нь шинжилгээний хариугаар батлагдсан. Дээрх шинжилгээнүүдийн хариу хэвийн гарсан бөгөөд шинжилгээний үр дүнг хавсралтаар оруулав.

Техникийн засвар үйлчилгээг хийхдээ тусгайлан бэлдсэн талбайд гүйцэтгэдэг бөгөөд шингэнийг зориулалтын саванд тосж аван, шүүлтүүрийг хатуу хог хаягдал буюу төмрийн хаягдалд тусад нь байрлуулсан.

**Зураг 19. Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс шинжилгээ хийж буй ажлын явц**

- Цэвэр болон тунаах нуураас дээж авч буй ажлын явц



- Хөрс болон овоолгоос дээж авч буй ажлын явц



- Агаар болон уурхайн орчинд шинжилгээ хийж буй ажлын явц





Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийсэн байршил	Хугацаа давтамж	Арга, аргачлал баримтлах стандарт	Зардлын тооцоо, төг
<b>1. Агаар орчин</b>					
Уурхайн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	Нийт тоосонцор PM10, PM2.5	Уурхайн бүсийн зонхилох салхины дээд болон доод талд Бааз дээр	8/23	MNS17.2.5.12:88, MNS17.2.511:88, MNS4048-88	73,500
Түлшний шаталтаас үүсэх хорт хийгээр агаар бохирдох	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub>	Уурхайн бүс болон бааз дээр	8/23		
Машин механизмын ажиллагаа хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	Шуугианы түвшин	Уурхайн бүс болон бааз дээр	8/23		
<b>2. Хөрсөн бүрхэвч</b>					
Хөрс элэгдэл эвдрэлд орох бохирдох гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Ялзмаг механик бүрэлдэхүүн давсны агууламж хөдөлгөөнт элемент	Нөлөөлөлд өртөөгүй болон нөхөн сэргээлт хийгдсэн талбайнууд	8/23	MNS3310:1991	92,900
Түлш тосолгооны материал болон хог хаягдлаар хөрс бохирдох	Хүнд металлын агууламж	Уурхайн засварын төв Шатахууны агуулах Хог хаягдлын цэг Автомашины зогсоол	8/23	MNS3310:1991	
<b>3. Гадаргын болон газрын доорх ус</b>					
Уурхайн технологийн хаягдал усаар ус орчин ба хөрс бохирдох	Ерөнхий хими ба хүнд металлын шинжилгээ /рН, Cl, SO <sub>4</sub> , NH <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , PO <sub>4</sub> , Cr6+, Fe/	Ул хөрсний ус Элс угаасан ус Тунгаагуурын ус	8/23	MNS6148:2010 ЗДХ	110,500
Ажилчдын унд ахуйн усны эрүүл ахуйн шаардлага	Хими болон микро-биологийн шинжилгээ	Ундны усны цорго	8/23	MNS900:2018	
Ахуйн хэрэглээний бохир усаар хөрс ус бохирдох	Хими болон микро-биологийн шинжилгээ	Цэвэрлэх байгууламжинд нийлүүлж буй болон гарч буй ус	8/23	MNS6561:2015	
Ажиллах хүчний томилолтын зардал					100,000
<b>Нийт зардал, мян.төг /томилолт, түлшний зардал орсон/</b>					<b>376.9</b>

## **8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд бий болж байна.

Байгаль орчныг хамгаалах болон аюулгүй ажиллагаатай холбогдсон сургалтыг 8 болон 10-р сард 2 удаа хийж гүйцэтгэсэн. Үр дүнд ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдол аливаа гэмтэл ослыг бууруулсан. Байгаль орчны удирдлагын тогтолцоо, нийгмийн хариуцлага болон эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, ирээдүйд гарч болзошгүй байгаль орчны эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаварыг тодорхойлох, тэдгээрийн арилгах арга хэмжээ авах замаар учирч болзошгүй алдагдал, хохиролоос сэргийлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмжтэй болсон.

Байгаль орчны удирдлагыг дараах чиглэлээр хэрэгжүүлж ажиллав. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах, түүний биелэлтэнд хяналт тавих зорилгоор Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг “Ногоо гэрэлт ирээдүй” ХХК-тай байгуулсан 2022/09 тоот гэрээний дагуу аудит хийлгэж хамтран ажиллаж байна.
- Байгаль орчныг хамгаалах болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан уурхайн ажиллагсдад ХАБЭА-н хичээл болон зааварчилгааг тогтмол өгч ажиллав.
- Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэсэн бөгөөд нөхөн сэргээлтийн ажлын явцыг орон нутгийн захиргаанд тайлагнаж байв.
- Уурхайн бүх ажлыг ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу явуулсан.
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл /газар хөдлөлт, үер, салхи шуурга/ болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг 8-р сард зохион байгуулав.
- Уурхайн ажиллагсдын дунд байгаль хамгаалах талаар ухуулга яриа, сурталчилгааны ажлыг 8-р сард зохион байгуулсан.
- Хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж, байнга бэлэн байлгаж ажилласан.
- Уурхайн ухааш, усан сан, ус хураагуурууд болон суваг шуудуу нь хүн, мал, амьтан унах, живж осолдохоос сэргийлсэн хаалт хийж эргэн тойронд нь анхааруулах, хориглох санамж байршуулсан.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч, ус, хөрс, агаарын бохирдол, хөрсний эвдрэл, элэгдэл, усны нөөцийн байдалд хяналт тавих зорилгоор Сэлэнгэ аймгийн “Ус цаг уур

орчны шинжилгээний төв”-гэй байгуулсан №27 тоот гэрээний дагуу хамтран ажиллав.

- Шатахуун хадгалах, түгээх станцын галын аюулгүй ажиллагааг найдвартай хангаж, тос шатахуун алдах, хаях, уурших явдлыг гаргахгүй байхад онцгой анхаарч ажилласан.
- Байгаль орчны менежментийн тайлангаа БОНХЯ-д болон орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгч, хянуулахаар ажиллаж байна.

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Зорилго	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	
1	Төслийн үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөө багаайгаар хэрэгжүүлэх	Монгол улсын байгаль орчны багц хууль, дүрэм, журам болон стандартын хэрэгжилтийг хангаж ажилласан. Ухагдсан орон зайд нөхөн дүүргэлт хийж биологийн нөхөн сэргээлтийг 1.65 га талбайд хийсэн.	2023 оны үйл ажиллагааны турш	Нөхөн сэргээлтийн зардалд тусгасан	
3		Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч, ус, хөрс, агаарын бохирдол, хөрсний эвдрэл, элэгдэл, усны нөөцийн байдалд хяналт тавих зорилгоор Сэлэнгэ аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-гэй байгуулсан №27 тоот гэрээний дагуу хамтран ажиллав.	8-р сар	Хяналт шинжилгээний зардал тусгасан	
4		Байгаль орчныг хамгаалах, түүний биелэлтэнд хяналт тавих зорилгоор Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг “Ногоо гэрэлт ирээдүй” ХХК-тай байгуулсан 2022/09 тоот гэрээний дагуу аудит хийлгэж хамтран ажиллаж байна.	2022-10-р сар	Өмнөх жилийн зардалд орсон	
5		“Бэрлэг Майнинг” ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргатай Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан гэрээний хүрээнд орон нутагт Байгаль орчинг хамгаалах талаар хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг цаг тухайд нь танилцуулж харилцан уялдаатай ажиллав.	2023 оны үйл ажиллагааны турш	6600.0	
6		Байгаль орчныг хамгаалах болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан уурхайн ажиллагсад ХАБЭА-н хичээл болон зааварчилгааг тогтмол өгч ажиллав. Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл /газар хөдлөлт, үер, салхи шуурга/ болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг 8-р сард зохион байгуулав.	8-р сар	600.0	
8		Нийт ажиллагсад байгаль хамгаалах, байгалийн баялаг ашиглах, асуудлаар 8-р сард сургалт зохион байгуулав	8-р сар	600.0	
			<b>Дүн</b>		<b>7800.0</b>

Зураг 20. ХАБЭА, Байгаль хамгаалах, байгалийн баялаг ашиглах болон байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл /газар хөдлөлт, үер, салхи шуурга/ болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх сэдвээр зохион байгуулсан сургалтуудын явц



Зураг 21. “Ногоо гэрэлт ирээдүй” ХХК-аас төлөвлөгөөт байгаль орчны аудит хийж буй ажлын явц





Зураг 22. “Сэлэнгэ Ой Ан Төв” ХХК-аас Хүдэр суманд мод тарьж буй ажлын явц



## 9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлэх ажлыг 2023 оны 10-р сарын 18-ны өдөр Бэрлэгийн цагаан тохойн уурхайн оффист нутгийн оршин суугчдын төлөөлөөс Д.Отгонбаатар (Ерөө сум, 2-р багийн малчин), Т.Энхбаатар (Бугант сум, 6-р багийн малчин), Б.Буянжаргал (Мандал сум, 6-р багийн малчин) нарын бүрэлдэхүүнтэйгээр хийсэн. Хамтарсан хурлын тэмдэглэлийг хавсралтаар оруулав.

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах оролцогч тал	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа давтамж	Зардал мян.төг	Төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах албан тушаалтан
Сум орон нутгийн иргэдийн хуралд	Танилцуулах болон санал хүсэлт авах	Нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлага	10 сард	Үйл ажиллагааны зардлаас	Компанийн захирал, Уурхайн дарга, Уурхайн байгаль орчин хариуцсан мэргэжилтэн, ХАБЭА хариуцсан ажилтан
Сум орон нутгийн ЗДТГ	Танилцуулах болон санал хүсэлт авах	Нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлага	Улирал тутам		
Орон нутгийн байгаль орчны байцаагч нарт	Танилцуулах болон санал хүсэлт авах	Үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн талаар	Улирал тутам		
Багийн засаг даргад	Танилцуулах болон санал хүсэлт авах	Үйл ажиллагааы талаар	Улирал тутам		
Нутгийн оршин суугчдад	Танилцуулах болон санал хүсэлт авах	Нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлага	10 сард		

Зураг 23. Орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй хамтарсан хурал



2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

Хүснэгт 14

Д/д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөлөийг бууруулах арга хэмжээны зардал	17,756.081
2	Техникийн нөхөн сэргээлтийн ажлын зардал	46,200.0
3	Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал	19,800.0
4	Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын зардал	84,280.0
5	Удирдлага зохион байгуулалтын болон бусад арга хэмжээ	7,800.0
6	Хяналт шинжилгээний ажлын зардал	376.9
7	Осол, эрсдэлийн менежментийн ажлын зардал	2,900.0
8	Хог хаягдлын менежментийн ажлын зардал	1,880.0
<b>Нийт зардлын дүн</b>		<b>180,992.981</b>